

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газар

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр
Утас: 70483413

Цахим хаяг:

Tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn

Аудитор Г.Энхдэлгэр

Цахим хаяг: Enkhdelgerg@audit.gov.mn

Аудитор Б.Цэвэлмаа

Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

ТАЙЛАНТАЙ ХОЛБООТОЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ WWW.TAILAN.AUDIT.MN ЦАХИМ ХАЯГААР
АВНА УУ.

АЛТАЙ ХОТ 2022 ОН



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 409

Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөгчдийн хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т үүрэг болгосугай.


Х.ТҮВШИНБАЯР

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторов
2022 оны 04 дугаар сарын 29-ны
өдрийн 109 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

ДД	Хариуцагч	Товч утга	Дугаар	Зөрчлийн дүн /сая.төгрөг/	8217 Аудитын нэр ДЮА0060 9018301
1	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	01/116	5.1	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
2	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	02/116	6.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
3	Аймгийн Засаг дарга	Төлбөр барагдуулах тухай	03/116	89.6	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
4	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	01/196	2,293.4	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
5	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	02/196	0	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	03/196	112.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
7	Тонхил сумын ЕБС	Зөрчил арилгуулах тухай	04/196	49.5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
8	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	05/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
9	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	06/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
10	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	07/196	28.9	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
11	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	08/196	18.6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
12	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	09/196	32.0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
13	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	10/196	32.3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
14	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	11/196	0	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
15	Аймгийн Засаг дарга	Зөрчил арилгуулах тухай	12/196	8.8	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
16	Орон нутгийн өмчийн газар	Зөрчил арилгуулах тухай	13/196	186.7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
	Нийт дүн			2,863.4	

Агуулга	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
Хүснэгтийн товъёг	3
Зургийн товъёг	3
АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ,	4
АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	6
А.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулсан байна.	7
А.1.2. Жагсаалтад батлагдсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн гэх баримт материал шалгагдагч этгээдэд байхгүй байна.	7
А.1.3. ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн баталж байна.	8
А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй судалгаа тооцоогүй ажлыг санхүүжүүлснээс төсөвт үргүй зардал бий болсон байна.	8
А.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна.	9
А.2.3. Батлагдсан төсөл, арга хэмжээний 32 хувь, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 40 хувь нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах урсгал зардалд зарцуулагдсан байна.	10
Б.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.	10
Б.1.2 Тайлант онд 2 төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжийг хангахуйц хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүйгээс хэрэгжээгүй байна.	11
Б.1.3. Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор ханган зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.	12
Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.	12
Б.2.1. 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй байна.	13
Б.2.2 Эрх бүхий этгээд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч худалдан авах ажиллагаанд заасан ажлын даалгавар, тоо хэмжээ хангагдаагүй ажлыг хүлээн авсан байна.	15
Б.2.3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэгчийн санал болгосон хугацаанаас хуанлийн 49 хоногийн дараа хяналт хэрэгжүүлж гүйцэтгэгчид чирэгдэл учруулсан байна.	16
Б.3.1 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.	16
Б.3.2. Ашиглалтад орж, захиалагч хүлээн авсан 186.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаж эзэмшигчийг тодорхой болгоогүй байна.	17
Холбогдох байгууллагын санал.....	19

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГАА	Говь-Алтай аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНТХО-аар 2021 онд хэрэгжсэн ТАХ	6
Хүснэгт 2	ОНТХО-ын ТАХ-ын хураангуй	10
Хүснэгт 3	Худалдан авах ажиллагааны хураангуй	12
Хүснэгт 4	Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ-ын үйлдвэрлэлийн төлөвлөгөө	14

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Тодорхой байршлын зураг	8

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт

“Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, газар дээрх нөхцөл байдалтай холбоотой төлөвлөлт хийсэн судалгаа шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, бий болсон өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт холбоотой баримт материалыг хамруулан аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, төсөл арга хэмжээний ашиглагч байгууллагад байгаа баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын хязгаарлалт

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тухайд аймгийн ИТХ-аас төсөв баталсан тодотгосон тогтоолд тусгагдсан төсөл арга хэмжээ болон өмнөх оны чанар байдал хангалтгүй, аудитаар шийдвэр өгсөн замын нөхөөс, Соёл амралтын хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө барих, хүүхдийн паркийн тоглоомын тоог нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэлийг хамруулсан.

**Аудитын арга
зүй, шалгуур
үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817:2020 3Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” MNS 6817:2020 3Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж стандартыг хангуулан, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Г.Энхдэлгэр, Б.Цэвэлмаа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 03-ны өдрөөс 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2022 оны 4 дүгээр сарын 16-аас 2022 оны 4 дүгээр сарын 18-нд хийж аудитын тайланг 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн аудит хамрах хугацаанд 3 удаа солигдсон, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер 1 удаа солигдсоноос зарим төсөл арга хэмжээний байрлал тодорхойгүй, аудитад шаардлагатай баримт материал гаргаж өгөх процесс удаашралтай байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2020 онд баталсан “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” тогтоол болон түүнд оруулсан тодотголоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгждэг 2 арга хэмжээнд (орон нутгийн хөрөнгө оруулалт, замын сан) 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 632.3 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. Батлагдсан төсөл, арга хэмжээний 60 хувийг замын сангийн төсөл арга хэмжээ 40 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ эзэлж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан 3 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй бөгөөд санхүүжилт олгогдоогүй, 7 төсөл, арга хэмжээнд 505.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Хүснэгт №1. ОНТХО-аар 2021 онд хэрэгжсэн ТАХ

ХЭРЭГЖСЭН ТАХ ҮЗҮҮЛЭЛТ / АРГА ХЭМЖЭЭ	сая.төг	
	ОНТХО	ЗАМЫН САН
ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ТОО	3	4
ХӨШӨӨ ДҮРСГАЛ	1	
ТӨСВИЙН ДЭМЖЛЭГ	1	
СУУДЛЫН АВТОМАШИН	1	
ЗАМЫН НӨХӨӨС ЗАСВАР		1
АВТО ЗАМЫН АВТОМАТ ХААЛТ		1
АВТО ЗАМЫН ХААЛТ ХАЙСНЫ МАТЕРИАЛ		1
ЯВГАН ЗАМ ӨРГӨТГӨХ ШИНЭЧЛЭХ		1
ТӨСӨВТ ӨРТӨГ	282.3	276.0
САНХҮҮЖИХ ДҮН	282.3	276.0
ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ	282.3	223.6

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн ОНТХО судалгаа

Шилэн данс: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

БҮЛЭГ А. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨТЭЙ ЭСЭХ

А.1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИСТОЙ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ БАЙНА УУ?

А.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулсан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын хавсралтаар “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ыг баталсан байна. Журмын дагуу төсвийн ерөнхийлөн захирагч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтлахаар байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон тухайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан байх
- ✓ Салбарын хөгжлийн бодлого, салбарын болон бүс нутгийн дунд хугацааны стратеги, мастер төлөвлөгөөний зорилтыг хэрэгжүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ байх
- ✓ Аймгийн ИТХ-ын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байх зэрэг болно.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аймгийн 2021 оны төсөв тодотгон батлах тухай” 12 дугаар тогтоолоор орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт арга хэмжээнд 320.0 сая төгрөг, автозам гүүрний байгууламж арга хэмжээнд 320.0 сая төгрөг зарцуулахаар баталсан боловч авто зам гүүрний байгууламж арга хэмжээнээс хэрэгжих төсөл, арга хэмжээний нэр байршлыг заагаагүй бөөн дүнгээр баталсан байна. Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дүгээр тушаалын 3 дугаар зүйлийн 3.1¹ дэх заалтыг зөрчсөн байна.

Аймгийн ИТХ нь 2021 оны төсөв баталсан тогтоолыг 2 удаа тодотгосон ба эхний тодотголоор (2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоол) орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 280.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг 280.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр дараагийн тодотголоор (2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоол) орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 312.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг 312.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төсөл, арга хэмжээгээр задалж баталсан байна.

Авто зам гүүрний байгууламж арга хэмжээнээс хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын төсөв баталсан, тодотгосон тогтоолуудад хэрэгжих төсөл, арга хэмжээгээр задалж батлаагүй боловч аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн А/203 дугаар захирамжийн хавсралтаар жагсаалтаар задалж баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь дээрх хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны баримт бичгүүдтэй уялдуулсан байна.

А.1.2. Жагсаалтад батлагдсан ТАХ-г хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн гэх баримт материал шалгагдагч этгээдэд байхгүй байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 1/1666 дугаартай албан бичгээр ирүүлсэн аймгийн 2021 оны төсөв боловсруулсан тооцоололд дурдсан 4 төсөл арга хэмжээ батлагдахдаа нийт төсөвт өртгийн тухайд өөрчлөгдөөгүй боловч төсөл, арга

¹ ТЕЗ, аймаг, нийслэл төвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, тухайн санхүүгийн жилийн төсөлд тусгахдаа дараах зарчмыг баримтална.

хэмжээнүүд бүгд солигдсон байна. Богино хугацаанд төсөл, арга хэмжээний нэр төрөл өөрчлөгдсөн боловч аймгийн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст энэхүү өөрчлөлт хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагын дагуу хийгдсэн гэж үзэх үндэслэлтэй баримт материал байхгүй байна.

Автозам гүүрний байгууламж арга хэмжээний тухайд Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40-өөс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлэхээр заасны дагуу төлөвлөгджээ.

Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар, явган зам өргөтгөх, шинэчлэх (Говь-Алтай, Есөнбулаг) төсөл, арга хэмжээний саналыг Есөнбулаг сумын ЗДТГ-аас ирүүлсэн тооцоо судалгаа, саналыг харгалзан төсөвт тусгасан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээ зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байсан эсэхийг судалж үзэхэд улс орны өнөөгийн нөхцөл байдал, хэмнэлтийн горим хэрэгжиж буй цаг хугацаанд хөшөө дурсгал, автомашин худалдан авах, явган зам өргөтгөх шинэчлэх ажилд хөрөнгө зарцуулсан нь цаг үеэ олоогүй оновчгүй хөрөнгө оруулалт болжээ.

Илрүүлэлт:

- Төсвийн хэмнэлтийн горим зөрчиж 32.0 сая төгрөгийн автомашин худалдаж авсан.

А.1.3. ТАХ-ний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дарааллыг олон нийтийн саналд үндэслээгүй аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн баталж байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр буюу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, автозам гүүрний байгууламж гэсэн 2 арга хэмжээнээс хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг богино дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн батлагдсан баримт бичгүүдэд нийцүүлэн баталж байгаа боловч Төсвийн тухай хуулийн ерөнхий зарчмын дагуу олон нийтийн санал аваагүй байна. Харин Төсвийн тухай хуульд тусгайлан заасан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнд цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цахимаар олон нийтээс санал авч ажиллажээ.

А.2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮР АШИГТАЙ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛСАН УУ?

А.2.1. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй судалгаа тооцоогүй ажлыг санхүүжүүлснээс төсөвт үргүй зардал бий болсон байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 2 арга хэмжээнээс хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төсөвт төлөвлөхдөө ажлын даалгавар, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үндэслэсэн байна.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Зураг №1 Тодорхой байршлын зураг



earth.google.com план зураг

Харин алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хөөн шалгаж, ирүүлсэн баримтын хүрээнд судалгаа хийхэд зурагт заасан 160 метр автозамыг (Зураг №1) засварлах, нөхөх ажил хийгдсэн байхад хуулсан байна.

Шалтгааныг тодруулахад Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2022 оноос 2023 онд хэрэгжих шинэ ажлын ангилалд зам тээврийн, хөгжлийн сайдын багцад XV.1.1.51 дугаартайгаар “Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 10 км (Говь-Алтай, Есөнбулаг сум)” нэртэйгээр 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил батлагдсанаар хуулалт хийгджээ. Энэ хэсэгт хийгдсэн ажлыг захиалагчаас ирүүлсэн хүсэлт, хяналт тавьсан этгээдийн ирүүлсэн баримт, гүйцэтгэгчийн ажил хүлээлгэн өгсөн баримт материал дээр ажиллан тооцоо хийх гэсэн боловч албан тушаалтанд солигдсон шалтгаанаар төсөвт хэр хэмжээний үргүй зардал бий болсныг тооцох хангалттай нотолгоо байсангүй. Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажилд захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ, дууссан, дуусгавар болсон ажлыг хүлээн авахдаа анх байгуулсан гэрээ, худалдан авах ажиллагаанд авагдсан ажлын тоо хэмжээ, ажлын даалгавар тус бүр нэр төрлөөр хангагдсан эсэхийг нарийвчлан тооцож үр дүнг бодитой баримтаар баталгаажуулах шаардлагатай байна.

Илрүүлэлт:

- ГХБХБГ нь захиалагчийн хяналтыг төлөөлөн хэрэгжүүлэхдээ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлээгүй байна.
- Захиалагчийн хяналт хэрэгжүүлэхдээ, дууссан, дуусгавар болсон ажлыг хүлээн авахдаа анх байгуулсан гэрээ, худалдан авах ажиллагаанд авагдсан ажлын тоо хэмжээ, ажлын даалгавар тус бүр нэр төрлөөр хангагдсан эсэхийг нарийвчлан тооцож үр дүнг бодитой тооцоогүй байна.

А.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр буюу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, автозам гүүрний байгууламж гэсэн 2 арга хэмжээнээс хэрэгжих төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын төсөв тодотгосон тогтоолд нэмж эцэслэн баталсан. Цаг хугацааны тухайд 2021 оны тайлант жилд хэрэгжих боломжит хугацаанд төсөл, арга хэмжээ болон түүний санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.

А.2.3. Батлагдсан төсөл, арга хэмжээний 32 хувь, хэрэгжсэн төсөл, арга хэмжээний 40 хувь нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах урсгал зардалд зарцуулагдсан байна.

Хүснэгт №2 ОНТХО-ын ТАХ-ын хураангуй (сая.төг)

ТАХ ҮЗҮҮЛЭЛТ / АРГА ХЭМЖЭЭ	ОНТХО		ЗАМЫН САН	
	БАТЛАГДСАН	ХЭРЭГЖСЭН	БАТЛАГДСАН	ХЭРЭГЖСЭН
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ТОО	4	3	6	4
ХӨШӨӨ ДУРСГАЛ	1	1		
АЗДТГ-Т ЦАХИМ СИСТЕМ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ	1			
ТӨСВИЙН ДЭМЖЛЭГ	1	1		
СУУДЛЫН АВТОМАШИН	1	1		
ЗАМЫН НӨХӨӨС ЗАСВАР			1	1
АВТО ЗАМЫН АВТОМАТ ХААЛТ			1	1
АВТО ЗАМЫН ХААЛТ ХАЙСНЫ МАТЕРИАЛ			1	1
ЯВГАН ЗАМ ӨРГӨТГӨХ ШИНЭЧЛЭХ			1	1
ПОСТ АЖИЛЛАХ ТҮР БАЙР			1	
АЛТАЙ СУМЫН ДАВАА ЗАСВАРЛАХ			1	
ТӨСӨВТ ӨРТӨГ	312.3	282.3	320.0	276.0
САНХҮҮЖИХ ДҮН	312.3	282.3	320.0	276.0
ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ		282.3		223.6

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн ОНТХО судалгаа

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 2 арга хэмжээнээс 632.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 6 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн 1 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 70 хувьтай гэрээ цуцлагдсан 1 төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа сунгагдсанаар санхүүжилт олгогдоогүй байна.

Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ-т төсвийн дэмжлэг 199.5 сая төгрөг, Хайс хийх материал нийлүүлэх 1.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагааг хангах урсгал зардалд зарцуулагдсан байна.

Ч.Лодойдамба агсны хөшөө барих ажлын үлдэгдэл санхүүжилт болох 50.8 сая төгрөгийг аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 11 дугаартай магадлалаар байгуулсан гэрээнд тусгасан ажлын үлдэгдэл хөлс, алдангийг гүйцэтгэгч талд олгохоор шийдвэрлэсний дагуу нөхөн олгосон байна.

Б. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ ЭСЭХ

Б.1. ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН УУ?

Б.1.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын төсөв баталсан, тодотгосон тогтоолд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн авто зам, гүүрний байгууламж арга хэмжээнээс хэрэгжихээр батлагдсан авто замын автомат хаалт, хайс хийх материал нийлүүлэх болон Алтай сумын зам засварлах гэсэн 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн “Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай” А/204 дугаар захирамжаар аймгийн Цагдаагийн газар, Алтай сумын Засаг дарга нарт олгосон байна.

Дээрх төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжих боломжтой хугацааг аймгийн Засаг даргын зүгээс олгосон байна.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Гэвч аймгийн Цагдаагийн газрын даргад эрх олгосон 8.8 сая төгрөгийн авто замын автомат хаалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон ба тоног төхөөрөмжийг хурлын тэмдэглэлээр хүлээн авсан боловч цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан одоо болтол суурилуулаагүй,

Алтай сумын Засаг даргад эрх олгосон зам засварлах ажлын гүйцэтгэгчтэй 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан гэрээг оролцогч 2 талын харилцан тохиролцоогоор 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сунгагдсан байна. Гэрээнд зааснаар гүйцэтгэгчид санхүүжилтийг ажил хийж гүйцэтгэж дууссаны дараа комисс хүлээн авч акт үйлдсэнээр 100 хувь олгохоор зааж 2021 онд санхүүжилт олгоогүй байна.

Б.1.2 Тайлант онд 2 төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжийг хангахуйц хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүйгээс хэрэгжээгүй байна.

Аймгийн ИТХ-ын төсөв баталсан, тодотгосон тогтоолд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 2 арга хэмжээнээс 632.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан ба үүний Ч.Лодойдамба агсны хөшөө барих ажлын үлдэгдэл санхүүжилт нь хуулийн байгууллагын шийдвэрийн дагуу хийгдэж байгаа учир, Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ-т төсвийн дэмжлэг нь тус нэгжийн урсгал үйл ажиллагаанд зарцуулагдаж байгаа учир, авто замын автомат хаалт, хайс хийх материал нийлүүлэх, Алтай сумын даваа засварлах гэсэн 3 төсөл, арга хэмжээ нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас² доогуур тул худалдан авах ажиллагаа төлөвлөж зохион байгуулах шаардлагагүй. Үлдсэн 5 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу худалдан авах ажиллагаа төлөвлөж зохион байгуулахаар байна.

Хүснэгт №3 Худалдан авах ажиллагааны хураангуй (сая.төгрөг)

ТАХ НЭР / АХ НЭР / ХАА ТӨРӨЛ	ОНТХО	АЗГБ	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА				
			НЭЭЛТ ТЭЙ	ХАРЬЦ УУЛАЛТ	ШУУД ГЭРЭЭ	ШААРДЛАГАГҮЙ ХЭРЭГ ЖЭЭГҮЙ	БУСАД
ГЭГЭЭН НУУР ЦЭВЭР УС ААТҮГ ТӨСВИЙН ДЭМЖЛЭГ	199.5						199.5
Ч.ЛОДОЙДАМБА АГСНЫ ХӨШӨӨ БАРИХ ҮЛДЭГДЭЛ САНХҮҮЖИЛТ	50.8						50.8
АЗДТГ-Т ЦАХИМ СИСТЕМ ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ	30.0					30.0	
ПОСТ АЖИЛЛАХ ТҮР БАЙР		24.0				24.0	
АЗДТГ-Т СУУДЛЫН АВТОМАШИН НИЙЛҮҮЛЭХ	32.0			32.0			
АЛТАЙ ХОТЫН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТОЗАМЫН НҮХНИЙ НӨХӨӨС ХИЙХ ЗАСВАР		171.4	171.4				
АВТОЗАМЫН АВТОМАТ ХААЛТ		8.8			8.8		
ХАЙС ХИЙХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ		1.9			1.9		
ЯВГАН ЗАМ ӨРГӨТГӨХ ШИНЭЧЛЭХ		93.9		93.9			
АЛТАЙ СУМЫН ДАВАА ЗАСВАРЛАХ		20.0			20.0		
ДҮН	312.3	320.0	171.4	125.9	30.7	250.3	54.0

Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан

² Засгийн газрын 2021 оны 124 дугаар тогтоол

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжих 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар аймгийн ЗДТГ-т цахим систем программ хангамжийн хөгжүүлэлт, пост

ажиллах түр байр барих гэсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлахаар төлөвлөсөн хугацаанаас 5-6 сараар хоцорч худалдан авах ажиллагаа зарласнаар тус 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Монгол Улсын Сангийн яамнаас 2022 оны 3 дугаар сард ирүүлсэн албан бичигт аймгийн Засаг даргын багцын 2021 оны “Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж зөвлөмж ирүүлсэн байна.

Б.1.3. Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй өрсөлдөх боломжоор ханган зохион байгуулж шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжихээр батлагдсан 10 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжилтийн агуулга, хэрэгжилтээр авч үзвэл 6 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн буюу Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.1³, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг баримтлан худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар байна. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.1⁴-т заасан журмыг оновчтой сонгон худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулан нийтэд мэдээлэн ажиллажээ.

Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.5⁵-т заасан хугацаа, Сангийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 102 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг баримтлан цахим системээр тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөө, тайланг явуулсан ба Сангийн яамнаас хэрэгжилтэд цахим системээр хяналт, шинжилгээ хийсэн байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг үнэн зөв гаргаж хугацаанд нь тайлагнасан байна.

³ 3.1-т Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

⁴ 7.1-т Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

7.1.1-т нээлттэй тендер шалгаруулалтын журам;

7.1.2-т тендер шалгаруулалтын онцгой журам;

7.3-т Захиалагч энэ хуулийн 8.1.2-т заасан босго үнээс бага төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг энэ хуулийн 7.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөхгүйгээр шууд худалдан авч болно.

⁵ 49.5-т Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

Б.2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН ХАНГУУЛЖ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?

Б.2.1. 1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжихээр батлагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилт дараах байдалтай байна.

1. Ч.Лодойдамба агсны хөшөө барих ажлын үлдэгдэл санхүүжилт ТАХ: Төсөл, арга хэмжээнд онд 50.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөн батлуулж гүйцэтгэлийг хангасан байна. Тус хөшөө нь 2017 онд баригдсан ба гэрээнд оролцогч талуудын маргаан хуулийн байгууллагаар шийдвэрлэгдэн 2021 онд үлдэгдэл санхүүжилт олгогдсон байна.



Тус төсөл, арга хэмжээний анх байгуулсан гэрээний дүн 85.0 сая төгрөг бөгөөд хөшөөний санхүүжилтийг олгохдоо иргэдийн хандиваас 32.7 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас 2018 онд 20.0 сая төгрөг, 2021 онд хуулийн байгууллагын шийдвэрийн дагуу 32.3 сая төгрөгийн үлдэгдэл төлбөр 18.6 сая төгрөгийн алдангийн

хамт гүйцэтгэгчид шилжүүлсэн байна. Хуулийн байгууллагын шийдвэрт тусгаснаар гэрээний үлдэгдэл төлбөр нь санхүүжилт байхгүй шалтгаанаар хийгдээгүйгээс гэрээний дагуу алданги тооцох үндэслэл бүрдсэн байна. Гэрээнд аймгийн ИТХ-ын дарга, санхүү төрийн сангийн хэлтсийн дарга нар зурснаар баталгаажсан ба тухайн үед гэрээний хэрэгжилтийг дүгнэж төлбөр тооцоог тодорхой болгож шийдвэрлээгүй захиалагчийн буруутай үйлдлээс төсөвт хохирол учирчээ. Цаашид төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үнэлж, дүгнэн сул зардал аль болох гаргахгүй ажиллах шаардлагатай.

2. “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ-т төсвийн дэмжлэг ТАХ:

Хүснэгт №4 Гэгээн нуур цэвэр ус ААТҮГ-ын үйлдвэрлэлийн төлөвлөгөө (сая.төг)

Төсөл, арга хэмжээнд 199.2 сая төгрөгийн төсвийн дэмжлэг олгосон бөгөөд “Гэгээн нуур цэвэр ус” ААТҮГ нь үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө хүрч ажиллаагүй, аймагт “Тайшир-Алтай усан хангамж” төсөл хэрэгжиж цэвэр усны хоолой тавигдаж ашиглалтад орсноор тус ААТҮГ-ыг татан буулгах шийдвэр гарч татан буулгах комисс ажиллаж байна.

Орлого, зардлын зүйл	Бүтээгдэхүүн	Төлөвлөлт		Гүйцэтгэл	
		тоо ширхэг	Мөнгөн дүн /сая төг/	тоо ширхэг	Мөнгөн дүн /сая төг/
1	2	3	4	5	6
Үйлдвэрлэл	18.9 литр	248,000	187.00	114,553	79.09
	0.5 литр	40,000	16.00	66,060	29.34
Үйлдвэрлэл	1.5 литр	10,000	6.50		29.34
	5 литр	20,000	32.00	1,000	2.50

3. Аймгийн Засаг даргын тамгын газарт суудлын автомашин нийлүүлэх ТАХ: Төсөл арга



хэмжээний гүйцэтгэгч “Морьт шагай” ХХК-д 32.0 сая төгрөг олгосон бөгөөд Toyota crown-S210 маркийн суудлын автомашин нийлүүлэгджээ. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолоор хориглосон хөрөнгө оруулалт хийсэн байна.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

4. Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар ТАХ: Төсөл, арга хэмжээ нь ажлын даалгавраар тоо хэмжээгээр хэмжигдсэн ба гүйцэтгэгчээр “Алтайн хүрд” ХХК ажиллаж нийт санхүүжилтийн 70 хувь 120.0 сая төгрөгийн санхүүжилт авч түүнд дүйцэх гэрээний үүргээ биелүүлэн бусад ажлыг хийхээс татгалзан гүйцэтгэгчийн зүгээс гэрээгээ цуцлах хүсэлт гарган шийдвэрлүүлсэн байна.



5. Автозамын автомат хаалт ТАХ: Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч “ДЭОЛС” ХХК-д 8.8 сая төгрөг олгожээ. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тоног төхөөрөмжийг нийлүүлэх суурилуулах ажил багтсан байна. Энэ төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргаас аймгийн Цагдаагийн газарт эрх шилжин хэрэгжсэн ба гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгчээ. Гэрээнд оролцогч талуудын байгуулсан гэрээний хугацаа дууссан боловч боловч заасан цэгүүдэд автозамын автомат хаалт суурилуулаагүй байна.

6. Хайс хийх материал нийлүүлэх ТАХ: Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч “Аранжин алтай” ХХК-д 1.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба автозамын хашлагыг аймгийн Цагдаагийн газар данс бүртгэлд тусган эзэмшин ашиглаж байна.



7. Явган зам өргөтгөх шинэчлэх ТАХ: Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч “Гуулин Эрдэнэ” ХХК-д 92.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Хүлээн авсан актад дурдсанаар 2040 м² явган зам тавьж ашиглалтад оруулсан байна. Явган зам тавьсан өнгөлгөөний тоосгыг гүйцэтгэгч компани өөрөө үйлдвэрлэсэн ба аймгийн ГХБХБГ-аас тус өнгөлгөөний тоосгоноос дээж аван шинжилсэн ба стандартын шаардлага хангаж байна гэж үзжээ.



8. Алтай сумын зам даваа засварлах ТАХ: Алтай сумын “Хавтгайтын гол”, “Алтан тоонотын гол”-ын зам засварын ажлыг гүйцэтгүүлэхээр иргэн Д.Отгонбаатартай гэрээ байгуулсан ба гэрээнд оролцогч талууд харилцан тохиролцсоноор гэрээний хугацааг 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сунгасан байна.

Илрүүлэлт:

- Ч.Лодойдамба агсны хөшөө барих ажлын үлдэгдэл санхүүжилт болох 32.3 сая төгрөгийн И баримт аймгийн Засаг даргын тамгын газрын төлбөрийн баримтын нэгдсэн системийн худалдан авалт төрөлд бүртгэгдээгүй.
- Ч.Лодойдамба агсны хөшөө барих ажлын үлдэгдэл нэрээр төсвөөс 18.6 сая төгрөгийн алданги төлсөн
- Цагдаагийн газрын даргад эрх олгосон 8.8 сая төгрөгийн авто замын автомат хаалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гүйцэтгэгчтэй 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр гэрээ байгуулж санхүүжилтийг бүрэн олгосон ба тоног төхөөрөмжийг хурлын тэмдэглэлээр хүлээн авсан боловч цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан одоо болтол суурилуулаагүй байна.

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

Б.2.2 Эрх бүхий этгээд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч худалдан авах ажиллагаанд заасан ажлын даалгавар, тоо хэмжээ хангагдаагүй ажлыг хүлээн авсан байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.12⁶-т зааснаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр ГХБХБГ-аас тавихаар байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжихээр батлагдсан харьяа төсвийн шууд захирагч руу эрх шилжээгүй 2 (автозамын автомат хаалт, явган зам өргөтгөх шинэчлэх) төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ хэрэгжүүлсэн боловч аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай тусгайлан байгуулсан гэрээ байхгүй байна.

Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар ТАХ: Төсөл, арга хэмжээ нь ажлын даалгаварт тусгасан тоо хэмжээгээр хэмжигдсэн ба гүйцэтгэгчээр “Алтайн хүрд” ХХК ажилласан бөгөөд захиалагчийн хяналтын баримт материалыг давтан үзэхэд гүйцэтгэгч нийт санхүүжилтийн 70 хувийг авч түүнд дүйцэх гэрээний үүргээ биелүүлэн бусад ажлыг хийхээс татгалзан гүйцэтгэгчийн зүгээс гэрээгээ цуцлах хүсэлт гарган шийдвэрлүүлжээ. Уг ажлын хүлээж авах комисс нийт ажлын 70 хувийг хийсэн тул хийгдсэн ажлын түвшинд төсөл, арга хэмжээг хүлээн авсан талаар хүлээн авсан ажил хүлээн авсан актад тусгасан байна.



Явган зам өргөтгөх шинэчлэх ТАХ: Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч “Гуулин Эрдэнэ” ХХК-д 92.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Ажлын тоо хэмжээ, баталгаажсан төсөвт зааснаар нийт 2500 м² явган зам тавихаас ажлын явцад захиалагчийн санаачилгаар замын боржур, 2 худгийн таг нэмж хийснийг хасаж 2040 м² явган зам тавьж ашиглалтад оруулсан байна. Явган замын нөхцөл байдалтай танилцахад зарим хэсгийн өнгө арилсан, эвдэрч бутарсан байна. Цаашид энэ төрлийн ажил хийхдээ материалын чанарыг төсөвлөлтөд нарийвчлан тусгаж урт хугацаанд ашиглагдах материал ашиглах нь зүйтэй байна.

Илрүүлэлт:

- Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засварын ажлын гүйцэтгэлтэй танилцахад зарим байршилд нөхөөс хуурсан

⁶ 3.12-т Улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр орон нутагт баригдах барилга байгууламжийн захиалагчийн хяналтыг тухайн аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан нэгжээр гэрээний үндсэн дээр төлөөлүүлэн гүйцэтгүүлж болно.

Б.2.3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэгчийн санал болгосон хугацаанаас хуанлийн 49 хоногийн дараа хяналт хэрэгжүүлж гүйцэтгэгчид чирэгдэл учруулсан байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 арга хэмжээнээс санхүүжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээнд зураг төсөв батлагдсан ажил байхгүй ба хэрэгжсэн ажлууд захиалагчаас гаргасан ажлын даалгавар, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг үндэслэсэн байх тул зохиогчийн хяналт хийгдээгүй байна. Харин захиалагчийн хяналтыг 2 төсөл, арга хэмжээнд хэрэгжүүлсэн бөгөөд хяналт хэрэгжүүлэх тодорхой хуваарь батлаагүй боловч төсөл, арга хэмжээний явцад нийт 5 удаа хяналт тавьсан байна. Ажил гүйцэтгэгчийн зүгээс гэрээнд заасан ажлаа дуусгасан талаар албан бичгээр хандсанаас хойш 49 хуанлийн хоногийн дараа хүлээн авчээ. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 37.1.12⁷-т заасан төрийн албан хаагчийн нийтлэг үүрэгтэй нийцэхгүй байна. Цаашид дээрх заалтыг баримтлан цаг хугацаатай хөрөнгө оруулалтын ажлыг хугацаа алдалгүй хүлээн авч шаардлагатай засвар сайжруулалтыг тухай бүр нь хийлгэж хэвших зайлшгүй шаардлагатай байна.

Б.2.4. Захиалагч, зохиогч мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ГХБХБГ нь алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар, явган зам өргөтгөх шинэчлэх төсөл арга хэмжээнд автозамын хяналтын улсын байцаагч, мэргэшсэн төсөвчин Г.Мөнхөөтэй “Автозамын ажилд зураг төсвийн зохиогчийн хяналт хэрэгжүүлэх” гэрээ байгуулан захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ба тухайн ажлуудын явцад илэрсэн 5 зөрчлийг ажлын явцад арилгах арга хэмжээ авсан талаар илтгэх хуудсанд бичсэн байна.

Б.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ, ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?**Б.3.1 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгоогүй байна.**

Автозамын автомат хаалт ТАХ: Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч “ДООЛС” ХХК-д 8.8 сая төгрөг олгожээ. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тоног төхөөрөмжийг нийлүүлэх суурилуулах ажил багтжээ. Гүйцэтгэгч тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн боловч заасан цэгүүдэд автозамын автомат хаалт суурилуулагдаагүй байхад захиалагчаас санхүүжилтийг 100 хувь олгосон байна. Төсөл, арга хэмжээг хүлээн авсан комисс газар хөлдсөн цаг үе таарсан учир бэлэн болсон тоног төхөөрөмжийг хүлээн авч үлдэх ажлыг дараа гүйцээн хийлгэхээр тэмдэглэл үйлджээ. Энэ талаар аймгийн Цагдаагийн газраас тодруулга авахад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны дотор ажлыг дуусган хүлээн авч данс бүртгэлд тулгахаар төлөвлөж байгаа талаар албан бичиг ирүүлсэн байна.

Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын нүхний нөхөөс хийх засвар ТАХ: Төсөл, арга хэмжээ нь ажлын даалгаварт тусгасан тоо хэмжээгээр хэмжигдсэн ба гүйцэтгэгчээр “Алтайн хүрд” ХХК ажилласан бөгөөд захиалагчийн хяналтын баримт материалыг давтан үзэхэд гүйцэтгэгч нийт санхүүжилтийн 70 хувийг авч түүнд дүйцэх гэрээний үүргээ биелүүлэн бусад ажлыг хийхээс татгалзан гүйцэтгэгчийн зүгээс гэрээгээ цуцлах хүсэлт гарган шийдвэрлүүлжээ. Уг ажлын хүлээж авах комисс нийт ажлын 70 хувийг хийсэн тул хийгдсэн ажлын түвшинд төсөл, арга хэмжээг хүлээн авсан боловч аудитаар засварын

⁷ 37.1.12-т төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй бай

“Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайлан

ажилтай танилцахад хэд хэдэн байршилд нөхөөс хийсэн хэсэг эвдэрсэн байлаа. Алтай сумын зам даваа засварлах ТАХ: Алтай сумын “Хавтгайтын гол”, “Алтан тоонотын гол”-ын зам засварын ажлыг гүйцэтгүүлэхээр иргэн Д.Отгонбаатартай гэрээ байгуулсан ба гэрээнд зааснаар гүйцэтгэгч ажлаа 100 хувь дуусгасны дараа санхүүжилт авах нөхцөлтэй тул тайлант онд ажлын тодорхой хувь хийгдсэн боловч санхүүжилт олгогдоогүй байна.

Илрүүлэлт:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын данснаас ОНХС-ийн 28.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.

Б.3.2. Ашиглалтад орж, захиалагч хүлээн авсан 186.7 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаж эзэмшигчийг тодорхой болгоогүй байна.

Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээнээс санхүүжин захиалагчийн зүгээс хүлээн авсан данс бүртгэлд тусгавал зохих 186.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон 3 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.



Данс бүртгэлд тусгаагүй ТАХ-ын зураг

Хүлээн авсан хөрөнгө оруулалтын ажлыг данс бүртгэлд тусган эзэмшигч, ашиглалтын хяналт тавих этгээдийг тодорхой болгохгүй байгаа нь зам талбайн ажлын насжилт хөрөнгийн үр ашигт сөргөөр нөлөөлж байна.

Илрүүлэлт:

- Ашиглалтад орж, захиалагч хүлээн авсан 186.7 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй.

Б.4. ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЗӨРЧЛИЙГ АРИЛГАСАН УУ?

Төрийн аудитын байгууллагын статистик мэдээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн өмнөх онуудын аудитаар өгөгдсөн 136.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 19.5 сая төгрөгийн 4 заалт албан шаардлага, 494.7 сая төгрөгийн зөвлөмж бүртгэлтэй байна. Үүнээс 16.5 сая төгрөгийн төлбөрийн акт, 494.7 сая төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан, 120.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 19.5 сая төгрөгийн 4 заалт албан шаардлагын хэрэгжилт хангагдаагүй байна.

Аймгийн Засаг даргаас өмнөх шийдвэрийн хэрэгжилтийг хангахаар үе шаттай ажил зохион байгуулж өөрийн дотоод аудитын нэгж болон хуулийн байгууллагад хандсан талаар 2022 оны 4 дүгээр сарын 19-ны өдрийн 2/475 дугаар албан бичигт дурдагдаж хавсралтаар нотлох баримтыг ирүүлсэн байна.

Аудитын байгууллагын шийдвэрийг цаг хугацаанд нь ханган хамтарч ажиллаагүйгээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас иргэд олон нийтийн хүртэх үр өгөөж буурах, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт удаашрах улмаар нэгэнт эхэлсэн ажлын төсөвт өртөг өсөх, үргүй зардал гарах, муу гүйцэтгэгчтэй олон удаагийн гэрээ байгуулах

гэх мэтээр төсвийн зардал нэмэгдэх шалтгаан болж байгааг онцгойлон анхаарч өгсөн шийдвэр болон түүний хэрэгжилтэд ач холбогдол өгч хамтарч ажиллах зайлшгүй шаардлага тулгарсан байна.

ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТООЦОО СУДАЛГААНД ТУЛГУУРЛАН ЦААШИД УРТ ХУГАЦААНД ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН НИЙГМИЙН ҮР АШИГ БИЙ БОЛГОХ, ИРГЭД ОЛОН НИЙТЭД ҮР ӨГӨӨЖ ӨГӨХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖИЛД ЗАРЦУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Дүгнэлтэд үндэслээд аймгийн засаг даргад 8 заалт 120.6 сая төгрөгийн албан шаардлага, аймгийн Орон нутгийн өмчийн газарт 1 заалт 186.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн Засаг даргад өгсөн албан шаардлага:



Аймгийн Иргэдийн Төлөөгчдийн Хурлын тогтоолоор баталсан арга хэмжээг санхүүжүүлэх



Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг үр ашигтай байхаар төлөвлөж хуваарилах



Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллаж



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчид олгосон санхүүжилтад худалдан авалтын И баримтыг нөхөн шивүүлэх



Захиалагчтай байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлж, чанаргүй, дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх



Захиалагчтай байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлж, чанаргүй, дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгүүлэх



Захиалагчийн хяналтыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх



Захиалагчийн хяналтыг үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт өгсөн албан шаардлага:




Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгах

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг, 82093

Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2022.04.28 № 1/556

танай _____-ны № _____-т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Х.ТҮВШИНБАЯРТ**

Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын дүгнэлтийг зөвшөөрөв.

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, дахин гаргахгүй байх талаар анхаарч хамтран ажиллах болно.



О.АМГАЛАНБААТАР

0204700550

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines, resembling notebook paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There is no text or other content on the page.